ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

## 2025 | I



www.ubstat.mn

Улаанбаатар хот
2025 он

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

**2025**
1сар

Улаанбаатар хот
2025

ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Хайх ...

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

## Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан

## Social network

/StatisticMGL

## Лавлах утас

1900-1212

## Цахим шуудан

information@nso.mn

**I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.**

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II. Дараах тэмдэглэгээг ашиглав.**

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

**III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ**

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- их наяд $=10^{12}$
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- $м^2$ метр квадрат
- $дм^2$ дециметр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори(=$10^9$ калори)
- с секунд
- мин минут
- мкг/$м^3$ микрограмм метр куб
- м/с метр секунд
- ш ширхэг
- х.д.х хэвлэлийн даралтат хуудас
- 
- Үнээс гадгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

**IV.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



**V**. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




**VI.** Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

ГАРЧИГ


Ерөнхий тэмдэглэл........................................................................................................4
Үндсэн үзүүлэлт.......................................................................................................6-7
I.Нийгмийн даатгал..................................................................................................8-10
II.Боловсрол...................................................................................................................11
III.Эрүүл мэнд..........................................................................................................12-15
IV.Гэмт хэрэг ..........................................................................................................16-18
V.Дүүргийн төсөв....................................................................................................19-22
VI.Хэрэглээний үнэ...................................................................................................23-27
VII.Дүүргийн аюулгүй байдал...................................................................................28-29
VIII.Аж үйлдвэр.........................................................................................................30-34
IX.Нийтийн аж ахуй ................................................................................................35-36
X.Төрийн бусад үйлчилгээ.........................................................................................37-42

| БҮЛЭГ | | ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН: |
|---|---|---|
| | Үндсэн үзүүлэлтүүд/хүснэгт/ | |
| I | Нийгмийн даатгал, халамж | А.Одгарав |
| II | Боловсрол | Н.Уранчимэг |
| III | Эрүүл мэнд | Н.Уранчимэг |
| IV | Гэмт хэрэг | Г.Пүрэвсүрэн |
| V | Дүүргийн төсөв | Г.Пүрэвсүрэн |
| VI | Хэрэглээний үнэ | Н.Уранчимэг |
| VII | Дүүргийн аюулгүй байдал | Г.Пүрэвсүрэн |
| VIII | Аж үйлдвэр | Н.Уранчимэг |
| IX | Нийтийн аж ахуй | А.Одгарав |
| X | Төрийн бусад үйлчилгээ | А.Одгарав |

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, Дүүргээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 I | 2025 I | Өөрчлөлт хувь |
|---|---|---|---|---|
| Шинэ төрсөн хүүхэд | тоо | 162 | 158 | -2.5% |
| Халдварт өвчнөөр өвчлөгсөд | тоо | 98 | 127 | 29.6% |
| Дүүргийн төсвийн орлого | тэрбум.төг | 17.4 | 13.8 | -20.7% |
| Дүүргийн төсвийн зарлага | тэрбум.төг | 14.5 | 16.3 | 12.4% |
| Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт | пункт | 0.7 | 1.3 | 85.7% |
| Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст | 1US$ =₮ | 3 410.69 | 3 420.46 | 0.3% |

## ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2023 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| | Өрхийн тоо | Хүн амын тоо | Өрхийн дундаж ам бүлийн тоо[1] | Хүн ам зүйн ачаалал[2] |
|---|---|---|---|---|
| **Дүүргийн дүн** | **37 736** | **136 280** | **3.6** | **57.5** |
| 1 -р хороо | 864 | 3 604 | 4.2 | 67.2 |
| 2 -р хороо | 969 | 3 384 | 3.5 | 67.4 |
| 3 -р хороо | 1 602 | 5 812 | 3.6 | 62.9 |
| 4 -р хороо | 1 265 | 4 936 | 3.9 | 56.5 |
| 5 -р хороо | 1 221 | 4 735 | 3.9 | 56.6 |
| 6 -р хороо | 2 510 | 9 020 | 3.6 | 64.4 |
| 7 -р хороо | 1 758 | 6 018 | 3.4 | 54.1 |
| 8 -р хороо | 958 | 3 314 | 3.5 | 53.0 |
| 9 -р хороо | 1 554 | 5 580 | 3.6 | 53.8 |
| 10 -р хороо | 1 920 | 7 226 | 3.8 | 57.5 |
| 11 -р хороо | 1 226 | 4 417 | 3.6 | 51.6 |
| 12 -р хороо | 1 598 | 5 713 | 3.6 | 57.1 |
| 13 -р хороо | 1 768 | 6 497 | 3.7 | 58.0 |
| 14 -р хороо | 1 618 | 5 827 | 3.6 | 55.2 |
| 15 -р хороо | 2 125 | 7 683 | 3.6 | 59.1 |
| 16 -р хороо | 1 980 | 7 647 | 3.9 | 57.9 |
| 17 -р хороо | 2 214 | 7 822 | 3.5 | 54.9 |
| 18 -р хороо | 2 230 | 7 366 | 3.3 | 53.5 |
| 19 -р хороо | 1 972 | 6 954 | 3.5 | 55.9 |
| 20-р хороо | 1 320 | 4 772 | 3.6 | 54.7 |
| 21-р хороо | 1 782 | 6 878 | 3.9 | 56.7 |
| 22-р хороо | 1 122 | 4 077 | 3.6 | 56.1 |
| 23 -р хороо | 1 249 | 4 302 | 3.4 | 59.7 |
| 24 -р хороо | 911 | 2 670 | 2.9 | 63.5 |

[1] Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

[2] Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

# I. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны 1 дүгээр сард 46.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.04(12.2%) тэрбум төгрөгөөр өсөж, сангийн зарлага 24.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.2(28.0%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 1.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг




Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 3.2(9.4%) тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 835.4(2.2 дахин ) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 372.0(10.0%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 535.4(23.7%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

ЗУРАГ 1.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 1.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг




Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 4.3(25.0%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ–ний даатгалын сангийн зарлага 19.3(17.5%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 592.7(2.4 дахин) тэрбум төгрөгөөр өсөж, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 592.7(37.3%) сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 70.8 мянган хүнд 8.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 26.0(27.0%) мянган хүнээр, олгосон тэтгэвэр, тэтгэмж 1.4(15.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 1.4 ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, сая төгрөг




Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 2334 хүн хамрагдаж 992.0 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 97(3.4%)-иар буурсан бол олгосон мөнгөн тэтгэвэр 206.4(26.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 56835 хүн хамрагдаж 5.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 8560(13.0%) хүнээр буурсан бол олгосон тэтгэмж 984.7(14.4%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

## Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

# II.БОЛОВСРОЛЫН САЛБАР

Дүүргийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдийн тоо 30229 болж өмнөх оны мөн үеэс 543 (1.8%) хүүхдээр нэмэгдсэн байна. 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд нийт 10251 хүүхэд хамрагджээ.

ХҮСНЭГТ 2.1 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД, ДҮҮРГЭЭР

| Сургалтын байгууллагын ангилал | 2018-2019 | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 |
|---|---|---|---|---|---|---|
| ЕБС-д суралцагчид бүгд | 26 785 | 27 781 | 29 741 | 28 791 | 30 772 | 30 229 |
| Үүнээс: Эмэгтэй | 13 384 | 13 993 | 14 912 | 14 330 | 15 272 | 15 111 |
| Бага | 14 939 | 14 767 | 15 427 | 12 689 | 15 497 | 14 117 |
| Дунд | 8 279 | 8 932 | 9 878 | 10 661 | 10 496 | 10 499 |
| Ахлах | 3 571 | 4 172 | 4 436 | 6 441 | 4 484 | 5 553 |

**Эх үүсвэр: Боловсролын хэлтэс*

ХҮСНЭГТ 2.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

| Үзүүлэлт | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 | 2022-2023 | 2023-2024 |
|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн тоо | 53 | 50 | 50 | 53 | 51 |
| Төрийн өмч | 31 | 32 | 35 | 38 | 39 |
| Төрийн бус өмчийн | 22 | 18 | 15 | 15 | 12 |
| СӨБ-д хамрагдагчид | 10 584 | 7 336 | 7 264 | 9 971 | 10 251 |
| Төрийн өмч | 8 941 | 6 268 | 6 276 | 8 825 | 9 401 |
| Төрийн бус өмчийн | 1 643 | 1 068 | 988 | 1 146 | 850 |
| Нийт ажилтан | 1 239 | 1 475 | 1 368 | 1 452 | 1 482 |
| Төрийн өмч | 1 037 | 1 222 | 1 240 | 1 322 | 1 372 |
| Төрийн бус өмчийн | 202 | 253 | 128 | 130 | 110 |
| Үндсэн багш | 305 | 488 | 391 | 425 | 422 |
| Төрийн өмч | 286 | 384 | 349 | 381 | 383 |
| Төрийн бус өмчийн | 64 | 104 | 42 | 44 | 39 |

**Эх үүсвэр: Боловсролын хэлтэс*

# ЭРҮҮЛ МЭНД, 2025 оны эхний 1 сарын байдлаар

ᠡᠷᠡᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

| | | |
|---|---|---|
| 2024 | 548 | |
| 2025 | 619 | 13.0% ↑ |

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид, 10 000 хүн амд

| | | |
|---|---|---|
| 2024 | 6.5 | |
| 2025 | 9.1 | 40.0% ↑ |

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

| | |
|---|---|
| 2024 | 6.2 |
| 2025 | 25.3 |

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

| | |
|---|---|
| 2024 | 0.0 |
| 2025 | 0.0 |

# IV. ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 157 эх амаржиж, 158 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 3(1.9%)-иар, мэндэлсэн хүүхэд 4(2.5%)-иар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3.1 ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2025 оны эхний 1 сарын байдлаар

| Үзүүлэлт | 2023 I | 2024 I | 2025 I | Өсөлт, бууралт 2024-2025 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| Амаржсан эхийн тоо | 196 | 160 | 157 | -3 | -1.9 |
| Амьд төрсөн хүүхэд | 197 | 162 | 158 | -4 | -2.5 |
| Нас барсан хүн | 67 | 47 | 98 | 51 | 2.1[1] |
| Эхийн эндэгдэл | - | - | - | - | - |
| 0-1 насны нялхасын эндэгдэл | 3 | 1 | 4 | 3 | 4.0[1] |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | - | - | - | - | - |
| Амьгүй төрөлт | - | - | 1 | 1 | 1.0[1] |
| Гэрийн төрөлт | - | 1 | - | -1 | -1.0[1] |
| Хяналтгүй төрөлт | 1 | 1 | 1 | - | - |

[1]-Дахин

** Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

2025 оны 1 дүгээр сарын байдлаар 77130 хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11043(16.7%) хүнээр, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 619 болж 7 (13.0%) хүнээр тус тус буурчээ.

ЗУРАГ 3.1 ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ХҮСНЭГТ 3.2 ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний 1 дүгээр сарын байдлаар

| Төрөл | 2023 I | | 2024 I | | 2025 I | | Өөрчлөлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | Бодит тоо | 10 000 хүнд ногдох | |
| **Дүүргийн дүн** | **129** | **8.6** | **98** | **6.5** | **127** | **9.1** | **29.6** |
| Гепатит | 1 | 0.1 | 2 | 0.1 | 1 | 0.1 | -50.0 |
| Цусан суулга | 6 | 0.4 | 4 | 0.3 | 4 | 0.3 | - |
| Сальмоненнез | 1 | 0.1 | 2 | 0.1 | - | - | -2.0[1] |
| Хоолны хордлого | - | - | - | - | - | - | - |
| Менингококкт | - | - | - | - | 1.0 | 0.1 | -1.0[1] |
| Салхин цэцэг | 64 | 4.2 | 40 | 2.7 | 54 | 3.8 | 35.0 |
| Гахайн хавдар | - | - | 2 | 0.1 | - | - | -2.0[1] |
| Улаан эсэргэнэ | 1 | 0.1 | 3 | 0.2 | 3 | 0.2 | - |
| Ёлом | - | - | - | - | 2 | 0.1 | 2.0[1] |
| Бруцеллёз | 1 | 0.1 | - | - | - | - | - |
| Гар, хөл, ам | - | - | 6 | 0.4 | 1 | 0.1 | -83.3 |
| Эритема | 8 | 0.5 | - | - | - | - | - |
| Хачигт энцефалит | - | - | - | - | - | - | - |
| Хачигт риккетсиоз | - | - | - | - | - | - | - |
| Улаан бурхан | - | - | - | - | - | - | - |
| Ковид-19 | - | - | - | - | - | - | - |
| Бусад | - | - | - | - | - | - | - |
| Тэмбүү | 15 | 1.0 | 18 | 1.2 | 29 | 2.1 | 61.1 |
| Төрөлхийн тэмбүү | - | - | - | - | - | - | - |
| Заг хүйтэн | 2 | 0.1 | 4 | 0.3 | 5 | 0.4 | 25.0 |
| Сүрьеэ | 18 | 1.2 | 7 | 0.5 | 15 | 1.1 | 2.1[1] |
| Мөөгөнцөр | 3 | 0.2 | 4 | 0.3 | 4 | 0.3 | - |
| Трихомониаз | 9 | 0.6 | 6 | 0.4 | 8 | 0.6 | 33.3 |
| ХДХВ/ДОХ | - | - | - | - | - | - | - |

[1]-Дахин

**Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

Бэлгийн замын халдварт өвчин 46 байгаа нь нийт халдварт өвчний 36.2 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

# ГЭМТ ХЭРЭГ, 2025 оны эхний 1 сарын байдлаар



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

| 2024 I | 2025 I |
|---|---|
| 420 | 477 |

13.6%↑

Дүүргээр




Гэмт хэргийн улмаас

| Хохирсон хүн | Гэмтсэн хүн | Нас барсан хүн |
|---|---|---|
| 450 | 79 | 23 |

# IV. ГЭМТ ХЭРЭГ

2025 оны 1 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 477 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 57(13.6%) хэргээр өссөн байна. Нийт гэмт хэргийн 71(14.9%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 6(1.3%) нь хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг хэрэг, 36(7.5%) нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг хэрэг, 125(26.2%) нь хулгайн хэрэг, 9(1.9%) нь дээрэмдэх хэрэг, 135(28.3%) нь залилан мэхлэх гэмт хэрэг, 66(13.8%) нь алдаатай гүйлгээ, гээгдсэн хөрөнгө завших хэрэг, 21 (4.4%) нь автотээврийн ХАБ, АЖ зөрчих гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, цагдаагийн хэлтсээр, төрлөөр

| Дүүргийн дүн | 2025 I | Үүнээс: Цагдаагийн I хэлтэс | Үүнээс: Цагдаагийн II хэлтэс |
|---|---|---|---|
| | **477** | **302** | **175** |
| Хүний амьд явах эрхийн эсрэг | 24 | 9 | 15 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 44 | 27 | 17 |
| Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг | 5 | 4 | 1 |
| Өмчлөх эрхийн эсрэг | 319 | 209 | 110 |
| Эдийн засгийн | 8 | 8 | 0 |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг | 4 | 3 | 1 |
| Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг | 4 | 4 | 0 |
| Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг | 4 | 4 | 0 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг | - | - | - |
| Соёлын өвийн эсрэг | 3 | 3 | - |
| Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг | - | - | - |
| Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих | 25 | 12 | 13 |
| Бусад | 37 | 19 | 18 |

**Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс*

ЗУРАГ 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

# Дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлага, 2025 оны эхний 1 дүгээр сард, тэрбум төгрөг

төсвийн орлого
/ төлөвлөлт, гүйцэтгэл сая.төг/

| | |
|---|---|
| 2024 I | 17 477.1 |
| 2025 I | 13 896.8 |

* урьдчилсан гүйцэтгэл

Төсөв 2025 I

| | |
|---|---|
| Татварын орлого | 98.9% |
| Татварын бус орлого | 1.1% |

төсвийн зарлага
/төлөвлөлт, гүйцэтгэл сая.төг/

| | |
|---|---|
| 2024 I | 14 556.1 |
| 2025 I | 16 295.8 |

= төсөв 2025 I
/саячилсан дүнгээр/

| | | |
|---|---|---|
| Цалин хөлс | 1 128.1 | 6.9% |
| Бараа, үйлчилгээний бусад зардал | 2.601.3 | 16.0% |
| Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 115.1 | 0.7% |

# V. ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нэгдсэн тэнцэл 2025 оны 1 дүгээр сард 2.4 сая төгрөг гарсан байна.

ЗУРАГ 5.1 ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 1 сард, сая төгрөгөөр




Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 1 дүгээр сард 13896.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6206.9(30.9%) сая төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 98.9 хувийг татварын орлого, 1.1 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

2025 оны эхний 1 дүгээр сард дүүргийн татварын орлого 13739.3 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 5936.0(30.2%) сая төгрөгөөр , татварын бус орлого 157.4 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 270.9(63.3%) сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

ЗУРАГ 5.2 ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



ХҮСНЭГТ 5.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөгөөр, 2025 оны эхний 1 сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт орлого ба тусламжийн дүн** | **20 103.7** | **13 896.8** | **-6 206.9** | **-30.9%** |
| А. Урсгал орлого | 20 103.7 | 13 896.8 | -6 206.9 | -30.9% |
| 1. Татварын орлого | 19 675.3 | 13 739.3 | -5 936.0 | -30.2% |
| 1.1. Орлогын албан татвар | 17 606.0 | 10 792.4 | -6 813.6 | -38.7% |
| 1.2. Өмчийн татвар | 169.6 | 183.4 | 13.8 | 8.1% |
| 1.3. Бусад татвар (төлбөр хураамж) | 1 899.7 | 2 763.5 | 863.8 | 45.5% |
| 2. Татварын бус орлого | 428.4 | 157.4 | -271.0 | -63.3% |
| Б. Хөрөнгийн орлого | - | - | - | - |
| В. Тусламжийн орлого | - | - | - | - |

**Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс*

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2025 оны 1 дүгээр сард 16295.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 8959.2(35.5%) сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 6.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 16.0 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 78.3 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөгөөр, 2025 оны эхний 1 сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **25 255.0** | **16 295.8** | **-8 959.2** | **-35.5%** |
| А. Урсгал зарлага | 21 227.6 | 15 355.7 | -5 871.9 | -27.7% |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 8 384.5 | 2 601.3 | -5 783.2 | -69.0% |
| 1.1. Цалин, хөлс | 1 471.4 | 1 128.1 | -343.3 | -23.3% |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 195.8 | 115.1 | -80.7 | -41.2% |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал | 6 717.4 | 1 358.2 | -5 359.2 | -79.8% |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | - | - | - | - |
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 12 843.1 | 12 754.4 | -88.7 | -0.7% |
| 3.1. Татаас | - | - | - | - |
| 3.2. Урсгал шилжүүлэг | 12 843.1 | 12 754.4 | -88.7 | -0.7% |
| Б. Хөрөнгийн зардал | 4 027.3 | 940.1 | -3 087.2 | -76.7% |
| Хөрөнгө оруулалт | 4 027.3 | 940.1 | -3 087.2 | -76.7% |

**Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс*

ЗУРАГ 5.3 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2025 оны эхний 1 сарын байдлаар



# VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар өслөө. 2025 оны 1 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.3 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 6.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар




Хэрэглээний үнийн индекс 2025 оны 1 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 1.9 хувь, согтууруулах ундаа, тамхи бүлгийн дүн 0.6 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 1.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 0.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байр бүлгийн үнэ 5.3 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 13.5 хувь, бусад бараа үйлчилгээ бүлгийн үнэ 1.4 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 6.1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2024-I / 2023-I | 2025-I / 2024-I | 2025-I / 2024-XII | 2025-I / 2024-XII |
|---|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **108.2** | **109.7** | **101.3** | **101.3** |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 111.5 | 108.7 | 101.9 | 101.9 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 104.0 | 104.0 | 100.6 | 100.6 |
| Хувцас, бөс бараа, гутал | 105.9 | 110.7 | 101.9 | 101.9 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 105.2 | 124.3 | 100.1 | 100.1 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 106.7 | 111.9 | 103.4 | 103.4 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 108.3 | 105.4 | 101.1 | 101.1 |
| Тээвэр | 100.0 | 102.7 | 100.1 | 100.1 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 100.3 | 101.7 | 100.0 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 103.5 | 106.1 | 100.8 | 100.8 |
| Боловсролын үйлчилгээ | 121.2 | 119.7 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 115.7 | 114.3 | 105.3 | 105.3 |
| Даатгал, Санхүүгийн үйлчилгээ | 102.3 | 113.5 | 113.5 | 113.5 |
| Бусад бараа, үйлчилгээ | 120.4 | 110.3 | 101.4 | 101.4 |

Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон захууд болох Алтжин, Бөмбөгөр, Нарантуул-2, Хүчит шонхор захуудаас авсан бараа бүтээгдэхүүний дундаж үнэ.

ЗУРАГ 6.2 АЛТАН ТАРИА ДЭЭД ГУРИЛ, АТАР ТАЛХНЫ ҮНЭ, жил бүрийн 1 сард, төгрөгөөр




ХҮСНЭГТ 6.2. БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, жил бүрийн 1 сард

| Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | 2023 I | 2024 I | 2025 I |
|---|---|---|---|---|
| Алтан тариа 1-р зэрэг | кг | 1 897 | 2 398 | 2 466 |
| Атар талх | ш | 2 223 | 2 500 | 2 566 |
| Цагаан будаа | кг | 4 450 | 4 300 | 3 826 |
| Шар будаа | кг | 3 425 | 3 150 | 4 066 |
| Хонины мах /ястай/ | кг | 9 240 | 11 638 | 14 665 |
| Үхрийн мах /ястай/ | кг | 11 974 | 14 491 | 17 827 |
| Адууны мах | Кг | 9 487 | 11 225 | 12 051 |
| Тахианы гуя | кг | 10 724 | 14 481 | 9 283 |
| Сүү задгай | л | 3 750 | - | 4 500 |
| Хорхой ааруул | кг | 23 979 | 28 374 | 33 496 |
| Өндөг | ш | 486 | 590 | 549 |
| Ургамлын тос | л | 10 899 | 9 000 | 9 491 |
| Алим, кг | кг | 8 329 | 7 111 | 7 000 |
| Банана, шар | кг | 8 440 | 7 000 | 6 500 |
| Төмс | кг | 1 396 | 1 500 | 1 442 |
| Лууван | кг | 2 236 | 2 739 | 2 466 |
| Сонгино | кг | 3 240 | 3 000 | 2 823 |
| Элсэн чихэр | кг | 3 549 | 4 000 | 4 327 |
| Эдийн саван "Popular" | ш | 1 300 | 1 500 | 1 500 |
| Угаалгын нунтаг "OMO" | ш | 5 874 | 7 500 | 7 599 |
| Аяга, таваг угаагч шингэн, "Fairy" | ш | 4 365 | 5 525 | 5 933 |

**Эх үүсвэр: Хэрэглээний үнийн мэдээ*

ЗУРАГ 6.3 НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.4 НЭГ КГ ЛУУВАН, ТӨМСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 сард, төгрөгөөр




ЗУРАГ 6.5 ШАТАХУУНЫ ҮНЭ, жил бүрийн 1 сард, төгрөгөөр



<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Хэрэглээний сагс:</u> Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

<u>Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:</u> Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

<u>Хэрэглээний үнийн индекс:</u> Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

<u>Тооцох аргачлал:</u>
Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum\left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

$I_{ct}^{L}$ – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)
*t* – тайлант үе
*i* – бараа, үйлчилгээ
*o* – суурь үе
$P_t^i$ - i барааны тайлант үеийн үнэ
$P_0^i$ – i барааны суурь үеийн үнэ
$Q_0^i$- i барааны суурь үеийн жин

# ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, 2025 оны эхний 1 сарын байдлаар

| Торгуулсан жолоочийн тоо | | | Торгуулсан нийт хэмжээ /сая,төгрөг/ | | |
|---|---|---|---|---|---|
| 2024 I | 2025 I | | 2024 I | 2025 I | |
| 7 841 | 7 517 | 4.1% ↓ | 120.5 | 146.4 | 21.5% ↓ |

## НИЙТ ЗӨРЧИЛ 7 517

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй. боловч тээврийн хэрэгсэл жолоодсон
126

Эгнээ байраа буруу эзэлсэн
151

Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон
767

Хориглосон нөхцөлөөр зогссон
1 188

Бусад
4 461



Хамгаалах бүс хэрэглээгүй
752

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэнүедээ тээврийн хэрэгсэл жолоодсон
70

Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн
2

# VII. ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Зам тээврийн осол, зөрчил: Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2025 оны 1 дүгээр сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 7517 зөрчил илрүүлж, 70 хүнд торгож, эрх хасах, 14 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 7.1 ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

| Торгууль | 2023 I | 2024 I | 2025 I |
|---|---|---|---|
| Торгуулсан хүний тоо | 10 647 | 7 841 | 7 517.0 |
| Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/ | 250.1 | 120.5 | 146.4 |

ХҮСНЭГТ 7.2 ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

| Зөрчлийн хэлбэр | 2023 I | 2024 I | 2025 I |
|---|---|---|---|
| **НИЙТ ЗӨРЧИЛ** | **10 647** | **7 841** | **7 517** |
| Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон | 167 | 84 | 70 |
| Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон | 61 | 72 | 126 |
| Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон | 748 | 758 | 767 |
| Хамгаалах бүс хэрэглээгүй | 368 | 665 | 752 |
| Хориглосон нөхцөлөөр зогссон | 3 501 | 2 817 | 1 188 |
| Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн | - | 1 | 2 |
| Эгнээ байраа буруу эзэлсэн | 226 | 186 | 151 |
| Бусад зөрчил | 5 576 | 3 258 | 4 461 |

**Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс*

# АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2025 оны эхний 1 сарын байдлаар

Уул уурхайн олборлох аж үйлдвэр /сая төгрөг/




Боловсруулах аж үйлдвэр /сая төгрөг/




Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /сая төгрөг/



# VIII. АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 26 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 3996.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4257.9(51.6%) сая төгрөгөөр өссөн.Үүнд: Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбар 262.6(40.6%) сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 137.7(19.1%) сая төгрөгөөр тус тус буурсан ээзлж байна.

ЗУРАГ 8.1   АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 3028.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3857.6(56.0%) сая төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын 2025 оны 1 дүгээр сарын борлуулалт 5094.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5162.1(50.3%) сая төгрөгөөр буурсан байна. Энэ бууралтад боловсруулах аж үйлдвэрлэл салбарын орлого 4854.1(54.6%) сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

## ХҮСНЭГТ 8.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| | Салбар | Нийт бүтээгдэхүүн | | | Өсөлт/Бууралт | | Бүтэц /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 I | 2024 I | 2025 I | Дүнгээр | Хувиар | |
| | | Сая.төг | | | | | |
| **Нийт дүн** | | **8 567.6** | **8 254.2** | **3 996.2** | **4 257.9** | **-51.6%** | **100.0%** |
| 1 | **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **1 066.3** | **646.8** | **384.2** | **-262.6** | -40.6% | 9.6% |
| | Нүүрс | 133.1 | 194.2 | 218.9 | 24.7 | 12.7% | |
| | Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт | - | - | - | - | - | |
| | Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт | - | - | - | - | - | |
| | Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 931.3 | 452.6 | 165..3 | 287.4 | -63.5% | |
| 2 | **Боловсруулах аж үйлдвэр** | **6 309.5** | **6 886.1** | **3 028.4** | **-3 857.6** | **-56.0%** | 75.8% |
| | Хүнс ундааны үйлдвэрлэл | 2 451.7 | 3 563.6 | 413.8 | -3 149.8 | -88.4% | |
| | Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл | 1 258.4 | 109.4 | 359.0 | 249.6 | 2.3[1] | |
| | Хувцас үйлдвэрлэл | 1 024.0 | 462.3 | 341.9 | -120.3 | -26.0% | |
| | Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 70.9 | 129.7 | 154.7 | 24.9 | 19.2% | |
| | Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа | 266.1 | 369.2 | 186.5 | -182.7 | -49.5% | |
| | Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 17.2 | 15.3 | 22.1 | 6.8 | 44.3% | |
| | Тавилга үйлдвэрлэл | 52.4 | 481.9 | 4.2 | -477.8 | -99.1% | |
| | Бусад боловсруулах үйлдвэрлэл | 1 168.8 | 1 754.6 | 1 546.2 | -208.4 | -11.9% | |
| 3 | **Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа** | **1 193.8** | **721.4** | **583.6** | **-137.7** | **-19.1%** | 14.6% |
| | Хог хаягдал цуглуулах, зайлуулах | 1 193.8 | 721.4 | 583.6 | -137.7 | -19.1% | |
| **Борлуулалтын орлого** | | **7 564.1** | **10 256.6** | **5 094.6** | **-5 162.1** | **-50.3%** | **127.5%** |

[1]-Дахин

Энэ оны 1 дүгээр сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн уул уурхай олборлох үйлдвэрлэл нь 384.2 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 262.6(40.6%) сая төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 3028.4 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3857.6(56.0%) сая төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа нь 583.6 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 137.7(19.1%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

| Салбар | 2023 I | 2024 I | 2025 | | 2025 I 2024 I |
|---|---|---|---|---|---|
| | | | I | Гадаад | |
| | Сая.төг | | | | Хувь |
| **Нийт дүн** | **7 564.1** | **10 256.6** | **5 094.5** | **4 649.5** | **-50.3%** |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 1 087.3 | 646.8 | 476.5 | - | **-26.3%** |
| Боловсруулах аж үйлдвэр | 5 282.9 | 8 888.5 | 4 034.4 | 4 649.7 | -54.6% |
| Ус хангамж, сувагжилтын систем | 1 193.8 | 721.3 | 583.6 | - | -19.1% |

2025 оны 1 дүгээр сарын байдлаар уул уурхайн олборлох аж үйлдвэрийн борлуулалт 5094.5 сая, боловсруулах аж үйлдвэрийн борлуулалт 4034.4 сая, ус хангамж, сувагжилтын системийн борлуулалт 583.6 сая төгрөг байна.

ЗУРАГ 8.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, салбараар, сараар, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёог ашиглан тооцно.

Тооцох аргачлал:

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum(\frac{Q_t}{Q_0}) \cdot W_0 \cdot 100$$

Qt- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

$Q_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

$P_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

$W_0$- Жин

# НИЙТИЙН АЖ АХУЙ, 2025 оны 1 сарын байдлаар

ЦЭВЭРЛЭСЭН ЗАМ ТАЛБАЙ - 1 800 мян $м^2$

АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО - 415.7 сая.төг

Гэр хороолол
374.2 сая.төг
90.0%

Албан газар
41.6 сая.төг
10.0%

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ



2024 I 9 489.8 мян.$м^3$

2025 I 8 883.4 мян.$м^3$

8 883.4 мян.$м^3$

Гэр хороолол
7 995 мян.$м^3$
90.0%

Албан газар
883.3 мян.$м^3$
10.0%

Дүүргийн хэмжээнд 2025 оны 1 сард 1800 мян.м2 талбай цэвэрлэж, 8883.4 мян.м3 хог тээвэрлэсэн байна. Ажил үйлчилгээний орлого 415.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 28.4 сая төгрөгөөр буюу (6.4%)-иар буурсан үзүүлэлттэй байна.

# IX. НИЙТИЙН АЖ АХУЙ

Чингэлтэй дүүргийн хувьд нийт цэвэрлэгээний ажил, хог хаягдлыг Тохижилт үйлчилгээний байгууллага болон Найши ХХК нь хариуцаж ажилладаг.

Дүүргийн хэмжээнд 2025 оны 1 сард 1800 мян.м$^2$ зам талбай цэвэрлэж, 8883.4 мян.м$^3$ хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 606.4 мян.м$^3$ (6.4%) буурсан байна.

Ажил үйлчилгээний орлого 415.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 28.4 сая төгрөгөөр (6.4%) буурсан байна. Орлогын эх үүсвэрийг ангилбал 90.0% гэр хорооллоос, 10.0%-ийг албан газраас олсон орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 9. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2025 оны 1 дүгээр сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2023 I | 2024 I | 2025 I | Өсөлт бууралт |
|---|---|---|---|---|---|
| Цэвэрлэсэн талбай | мян.м$^2$ | 1 800.0 | 1 800.0 | 1 800.0 | - |
| Тээвэрлэсэн хог | мян.м$^3$ | 9 620.5 | 9 489.8 | 8 883.4 | -6.4 |
| Орон сууц | Тн | - | - | - | - |
| Гэр хороолол | тн | 8 658.5 | 8 540.8 | 7 995.0 | -6.4 |
| Албан газар | тн | 962.1 | 949.0 | 888.3 | -6.4 |
| Зам талбай | Тн | - | - | - | - |
| Ажил үйлчилгээний орлого | сая.төг | 450.2 | 444.1 | 415.7 | -6.4 |
| Зам талбай | сая.төг | - | - | - | - |
| Гэр хороолол | сая.төг | 405.2 | 399.7 | 374.2 | -6.4 |
| Орон сууц | сая.төг | - | - | - | - |
| Албан газар | сая.төг | 45 | 44.4 | 41.6 | -6.3 |

**Эх үүсвэр: Найши ХХК*

# X. ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

**Иргэний бүртгэлийн үйлчилгээ:** 2025 оны 1 дүгээр сарын байдлаар Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээ 4700 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 136(2.8%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрлэлт, гэр бүл цуцлалт, овог нэр өөрчлөх, шилжин ирсэн бүртгэл, иргэний үнэмлэх дахин олголт тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10.1 ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

| Үзүүлэлт | 2024 I | 2025 I | 2024 I<br>2025 I |
|---|---|---|---|
| | Дүнгээр | Дүнгээр | хувь |
| **Нийт** | **4 836** | **4 700** | **-2.8** |
| Шинэ төрсөн | 237 | 312 | 31.6 |
| Гэрлэлт | 64 | 43 | -32.8 |
| Гэр бүл цуцлалт | 30 | 24 | -20.0 |
| Хүүхэд үрчлэлт | 2 | 4 | 1 |
| Эцэг тогтоосон | 17 | 9 | -47.1 |
| Овог, нэр өөрчлөх | 11 | 7 | -36.4 |
| Шилжин ирсэн | 330 | 319 | -3.3 |
| Лавлагаа | 2 873 | 3 007 | 4.7 |
| Иргэний үнэмлэх олголт: | 1 272 | 975 | -23.3 |
| 16 нас хүрч шинээр авсан | 267 | 242 | -9.4 |
| Дахин олголт | 1 005 | 733 | -27.1 |

** Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс*

# ОНЦГОЙ БАЙДАЛ, 2025 оны эхний 1 сарын байдлаар



Онцгой байдлын хэлтэс нь 2025 оны эхний 1 сарын байдлаар нийт 65 гал түймэр, гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор буюу (51.1%)-иар өссөн байна.



**Онцгой байдал:** Онцгой байдлын хэлтэс нь 2025 оны 1 дүгээр сарын байдлаар үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт 65 гал түймэр гамшиг ослын дуудлагаар ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор (51.1%) өссөн байна.

ХҮСНЭГТ 10.2. ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2024 I | 2025 I | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Дуудлагын тоо | Тоо | 43 | 65 | 51.1 |
| Гал түймэр | Тоо | 37 | 46 | 24.3 |
| Иргэд унтраасан гал түймэр | Тоо | 6 | 7 | 16.7 |
| Өөрөө унтраасан гал түймэр | Тоо | 0 | 11 | 11.0[1] |
| Худал дуудлага | Тоо | 0 | 1 | 1.0[1] |
| Ажилласан цаг | Цаг.мин | 865 | 940 | 8.7 |
| Ашиглагдсан ус | Тонн | 150.7 | 115 | -23.7 |
| Ашиглагдсан шатхуун /дизель/ | Литр | 1 409 | 1 184 | -16.0 |
| Ашиглагдсан хөөс | Литр | - | - | - |
| Зарцуулсан мөнгө | Сая.төг | 4.4 | 3.7 | -15.9 |
| Аварсан хүний тоо | Тоо | 14 | 203 | 14.5[1] |
| Унтраасан барилга байшингийн тоо | Тоо | 17 | 35 | 2.1[1] |
| Нийт өмч хөрөнгө | Сая.төг | 760 | 5 260 0 | 7.0[1] |
| Амьсгалын бие даасан төхөөрөмж | Тоо | 125 | 146 | 16.8 |

[1]-дахин их

** Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ*

# ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, 2025 оны эхний 1 сарын байдлаар



| | Эд хөрөнгийн бүртгэл | Газар | Газраас бусад |
|---|---|---|---|
| Үйлчилгээний тоо | 1 322 | 492 | 825 |
| Үйлчилгээний хөлс (мян.төг) | 18 730 | 3 765 | 14 965 |

## ҮҮНЭЭС:



Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ: 2025 оны 1 дүгээр сарын байдлаар Улсын бүртгэлийн хэлтэс нь 7 төрлийн үйлчилгээг нийт 2639 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 37.4 сая төгрөгийн хураамж авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан хүн 27(1.0%) буурч, үйлчилгээний хөлс 4.9(15.2%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 10.3 ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, төрлөөр

| Үйлчилгээний төрөл | 2025 I сар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эд хөрөнгийн бүртгэл | | Газар | | Газраас бусад | |
| | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) |
| **Нийт** | **1 322** | **18 730** | **492** | **3 765** | **825** | **14 965** |
| Анхны бүртгэл | 104 | 140 | 24 | 80 | 75 | 60 |
| Өмчлөх эрх шилжих гэрээ | 289 | 5 768 | 99 | 1 980 | 190 | 3 788 |
| Барьцааны гэрээ | 753 | 12 254 | 273 | 1 477 | 480 | 10 777 |
| Бусад гэрээ | 7 | 50 | - | - | 7 | 50 |
| Бүртгэлд өөрчлөлт оруулах | 102 | 504 | 49 | 224 | 53 | 280 |
| Урьдчилсан тэмдэглэл | 1 | - | 1 | - | - | - |
| Лавлагаа хуулбар | 66 | 14 | 46 | 4 | 20 | 10 |

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс*

Улаан загалмай: Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 1 сарын байдлаар 1863 хүнд 894 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 657 хүнээр буурч, зарцуулсан зардал 2441.0 мянган төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 10.4 ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, төрлөөр эхний 1 сард

| Үзүүлэлт | 2024 I | | | 2025 I | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ |
| **Дүн** | **40** | **2 520** | **3 335** | **51** | **1 863** | **894 0** |
| Халамж үйлчилгээ | 5 | 275 | 2 775 | 1 | 10 | 66.0 |
| Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 6 | 208 | 300.0 | 1 | 21 | 42.0 |
| Анхны тусламжийн сургалт | 3 | 141 | 70.0 | 6 | 189 | 180.0 |
| Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа | 5 | 250 | 40.0 | 2 | 23 | 10.0 |
| Гамшгийн тусламж | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа | 0 | 0 | 0 | 3 | 138 | 230.0 |
| Донорын өдөрлөг, сурталчилгаа | 5 | 1 500 | 40.0 | 3 | 117 | 0 |
| Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 1 | 31 | 10.0 | 7 | 165 | 150.0 |
| Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа | 15 | 115 | 100.0 | 28 | 1 200 | 216.0 |

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо*

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 1 удаа зохион байгуулж 21 иргэн, анхны тусламжийн сургалт 6 удаа зохион байгуулж 189 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээр сургалтыг 7 удаа зохион байгуулж 165 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 28 удаа зохион байгуулж 1200 иргэнийг тус тус хамруулсан байна.

Захиргааны мэдээлэл: Дүүргийн хэмжээнд 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 256 иргэдээс өргөдөл, гомдол ирснээс 186-г хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 70 нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна. Ирүүлсэн өргөдөл гомдлын 73 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна.

ХҮСНЭГТ 10.5 ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, жил бүрийн эхний 1 сарын байдлаар

| Ангилал | 2025 I | Үүнээс: | |
|---|---|---|---|
| | | Шийдвэрлэх шатандаа байгаа | Шийдвэрлэж хариу өгсөн |
| **Нийт** | **256** | **70** | **186** |
| Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв | 2 | 1 | 1 |
| Нутгийн захиргааны байгууллагууд | 154 | 48 | 106 |
| 1800-1200 дугаарын оператор | 10 | 2 | 8 |
| 11-11 төвөөс ирсэн | 88 | 19 | 69 |
| Гар утасны аппликэйшнээр ирсэн | - | - | - |
| Мессеж | - | - | - |
| E-Service | 2 | - | 2 |
| Facebook | - | - | - |
| Дижитал сити | 22 | - | 22 |
| Хороо бүртгэсэн | - | - | - |
| НМХГ тусгай дугаар | - | - | - |

** Эх үүсвэр: Дүүргийн өргөдөл, гомдлын мэдээ*

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: ................................ /Д.МӨНХЗУЛ/

Танилцуулгыг нэгтгэсэн мэргэжилтэн: .............................. /А.ОДГАРАВ/